



11 дүгээр анги Нийгэм судлал

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ

Америкийн судлаач Ө.Күүс 1990-ээд онд нийгэм-эдийн засгийн ялгаа бүхий гурван ангийн хүмүүс өөрсдийн өвчний шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалжээ. Тэрээр **нэг дэх ангид эдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн амжилттай байгаа, хоёр дахид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг, гурав дахид ур чадвараар бага, даржин амьдралтай хэсгийнхнийг багтаан судалсан байна.** Нэг дэх ангийн хүмүүс өвчний нэг шинж тэмдэг илрэхэд эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ эрэлхийлэхэд бэлэн байсан бол харин гурав дахь ангийн хүмүүсийн 75 хувь нь өвчний 17 шинж тэмдгийн 10-ыг эмнэлэгт үзүүлэх ноцтой шинж биш гэж үзжээ. 2013 онд ЭМШУИС-иас хийсэн судалгаагаар бага орлоготой хүн ам, хөдөөгийн малчид, оюутан залуус эрүүл мэндийн үйлчилгээний бодит хэрэгцээ тулгарах үед эмнэлгээр үйлчлүүлдэг болох нь тогтоогджээ.

Социологч Д.Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ багаар эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь нэгдүгээрт санхүүгийн боломж, хоёрдугаарт, ядуусын соёл, гуравдугаарт, нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой хэмээн дүгнэжээ.

1. Нийгмийн гишүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ эрэлхийлэх зан үйлд юу нөлөөлж байна вэ?
2. Ө.Күүс нийгмийн гишүүдийг гурван ангид хуваан судалсны учир юу вэ?
3. Анги гэж юуг хэлдэг вэ?

Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамааран шийдвэр гаргахад оролцох боломжоор нийгмийн гишүүд харилцан адилгүй байна




Үйлдвэрт ямар машин техник авах вэ гэдгийг шийдэхэд жирийн ажилчин хүн оролцох боломжоор хомс бол инженер техникийн ажилтан, менежерүүдийн хувьд саналаа илэрхийлэх, цаашлаад шийдвэрийг гаргахад шууд оролцож байдаг.

Ямар байр суурь эзэлж байгаа нь цалин хөлс, орлогын хэмжээнд нөлөөлж байна.



Жишээ нь, уул уурхайн салбарт ажиллагсад улсын дунджаас 2 дахин илүү цалинтайгаар ажиллаж байна.



EQUALITY

EQUITY

Ямар байр суурьт хүрэх вэ гэдэг нь хувийн болон институтийн хүчин зүйлсээс хамаардаг.



Авьяас чадвар, хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөр гэсэн хувийн хүчин зүтгэлээс хамаарч байна.




Өсч торнисон гэр бүл, сурч боловсрох сургуулийн орчин нь түүнийг авьяасаа хөгжүүлэх, ашиглах боломжийг олгоогүй.



Нийгмийн ялгарал	Нийгмийн гишүүд хувийн нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ.
Тэгш бус байдал	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг хэлнэ.
Нийгмийн давхраажилт	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
Нийгмийн давхраа	Баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг
Нийгмийн нийтлэг	Ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл

МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ 2015 ОН



- 2% ● Чинээлэг
- 12% ● Дундын дээд
- 41% ● Дундаж
- 34% ● Дундын доод
- 11% ● Доод

ORONSUUTS.com
үн хэрглэх хөрөнгийн портал сайт



Орчин үед нийгмийн давхраажилтыг хэрхэн судалж байна вэ?

Функциональ зөрчилдөөний онол

Марксын ангийн ялгаа нь ашиг сонирхлын ялгаа, улмаар зөрчилд хүргэдэг гэсэн санаанд тулгуурладаг ч, ангийн ялгарлыг өмчийн гэхээсээ эрх мэдлийн ялгаатай түлхүү холбон үзсэн.

Орчин үеийн нийгэмд **бюрократи** байгууллагад эрх мэдэл ажилтнуудад тэгш бусаар хуваарилагдсан байдаг нь ноёрхогч хийгээд дагагч гэсэн хоёр ангид хуваагдахад хүргэдэг.

Тулгуур ойлголт. Бюрократ байгууллага. Нэгдмэл зорилгыг хэрэгжүүлэхээр шаталсан удирдлагын тогтолцоо бүхий, дүрэм журмаар бүхий л ажилтнуудын эрх, үүргийг тодорхойлсон, албан ёсны хөдөлмөр хуваарилалт бүхий байгууллага.



Неомарксистууд буюу шүүмжлэлт

онолынхон К.Марксын санааг

М.Веберийн үзэл баримтлалаар засах оролдлого хийдэг буюу өмчөөс гадна эрх мэдлийн ялгарлыг чухалчилдаг.

Тэд төр нь ноёрхогч ангийн эрх ашгийг хэрэгжүүлж байдаг гэсэн сонгодог

марксизмын үзэл санааг

үргэлжлүүлэн, нийгмийн халамжийн

болон эдийн засгийн хямралаас


сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх

замаар капиталист нийгэмд хувьсгал

гарахаас сэргийлж байна хэмээн

дүгнэдэг.

Марксын үзэл санаанд тулгуурлан, М.Веберийн үзэл санааг харгалзан нийгмийн давхраажилтыг судалсан судлаач бол **Е.О.Райт** юм. Тэрээр К.Марксын үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харьцаа (өмч)-ны ялгарлыг чухалчилсан үзэл санааг үйлдвэрлэлийн харилцаан дахь М.Веберийн “хянах” эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулан судалсан юм. Судалгааны үр дүнд **капиталист, менежер, ажилчин, жижиг хөрөнгөтөн** гэсэн дөрвөн ангийг тодорхойлсон. Түүнийхээр **капиталист нь** үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч, бусдын хөдөлмөрийг хөлслөгч, бусдын хөдөлмөрийн үйл ажиллагааг хянагч юм. **Менежер** нь өөрийн хөдөлмөрөө борлуулагч, капиталистуудын төлөө бусдын хөдөлмөрийн үйл ажиллагааг хянагч. **Ажилчин нь** өөрийн хөдөлмөрөө капиталистад борлуулагч, хянах эрх мэдэл үгүй анги юм. Харин **жижиг хөрөнгөтөн нь** өөрийн үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөгч, цөөн ажилтан хөлслөх тохиолдолд тэдний хөдөлмөрийн үйл ажиллагаанд хяналт тавигч эсвэл ажилтангүй тохиолдолд хяналт тавих эрх мэдэлгүй анги хэмээн үзсэн. Түүний судалгаагаар хувь хүний орлого, боловсролын зөрүүтэй байдал эдгээр дөрвөн ангийн харьяаллаас хамаарч байгааг басхүү илрүүлсэн байна.



Карл Маркс
1818 — 1883

КАПИТАЛ, КОММУНИСТ НАМЫН ТУНХАГ ЗЭРЭГ БҮТЭЭЛДЭЭ НИЙГМИЙН ЯЛГАРЛЫН АСУУДЛЫГ АВЧ ҮЗСЭН. ТЭРЭЭР АНГИ ХООРОНДЫН ХАРИЛЦААГ МӨЛЖЛӨГИЙН ШИНЖТЭЙ ГЭЖЭЭ. КАПИТАЛИСТ НИЙГМИЙН ҮЕД ӨМЧЛӨГЧ БАЯЛГИЙН ИХЭНХ ХУВИЙГ, ХАРИН АЖИЛЧИД ӨЧҮҮХЭН ХУВИЙГ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС НЭРИЙН ДОР МӨЛЖЛӨГӨД ӨРТДӨГ.




“АНГИ, СТАТУС, НАМ” 1920 БҮТЭЭЛДЭЭ ДАВХРААЖИЛТЫН АСУУДЛЫГ ХӨНДСӨН. АНГИЙН ЯЛГАРАЛД ӨМЧӨӨС ГАДНА ОРЛОГО, ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ МЭРГЭЖИЛ ЧУХАЛ ГЭЖ ҮЗСЭН. ТҮҮНЧЛЭН ТЭРЭЭР ДАВХРААЖИЛТЫН СУДАЛГААНД СТАТУСЫН БҮЛЭГ, НАМЫН ЯЛГАРЛЫН АСУУДЛЫГ СУДАЛСАН. СТАТУСЫН БҮЛЭГ НЬ НИЙГМИЙН БҮЛГҮҮДИЙН НЭР ХҮНДИЙН ЯЛГААТАЙ ХОЛБООТОЙ. НАМ НЬ АШИГ СОНИРХЛООРОО ЯЛГААТАЙ БҮЛЭГ ХҮМҮҮС БӨГӨӨД ЭРХ МЭДЛИЙН ЯЛГАРЛЫГ ИЛТГЭНЭ.


Бүтэц-чиг үүргийн онол



Э.Дюркгейм нарын социологичид анхнаасаа нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарлыг нийгмийн давхраажилтын суурь шалтгаан гэж үздэг. Тэд хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүргэх үндсэн шалтгаан гэжээ.



Т.Парсонс тухайн нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээрээ үнэлэгдэж, зэрэглэгдэж байдаг. Тэгэхээр бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг



Л.Уорнер Тэрээр хувь хүний ангийн харьяаллыг нийгэм-эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих бус, харин бусад хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүндийн субъектив үнэлгээ, хүндлэлээр хэмжих загварыг боловсруулсан юм. Тодруулбал, дэлгүүрийн эзэн эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзнээс дээд ангид оруулах замаар судална. Энэхүү аргачлалыг жижиг орон нутгийн хувьд ашиглаж болох ч, томоохон хот сууринд ашиглахад хүндрэлтэй юм.

ДАВХРААЖИЛТЫН ХЭВ МАЯГ



Нээлттэй
нийгэм

Хаалттай
нийгэм

Боол

Каст

Анги
бүлэг

Язгуур
угсаа

Онцлог
субъектив

Ажил
мэргэжил

Үе
залгамжилсан
удам угсаа

Олонд
танигдсан
байдал


Онцгой авьяас
чадвар

Нэр хүнд



Хүн болгон
өзрийн гэсэн
онцгой авьяастай

БРАХМАН	Энэ кастад санваартан, багш, сэтгэгчид багтана.
КШАТРИЙ	Төрийн захиргааныхан, цэргийнхэн, хууль сахиулагчид багтана
ВЯШНЯ	Газар тариалан эрхлэгчид, үхэр маллагч, худалдаачид багтана.
ШУДРА	Гар урчууд болон үйлчлэгчдийг орууладаг
ДАЛИТ	Хүрч боломгүй хүмүүс



Язгуур



Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай

Эрх зүйн хувьд баталгаажсан

Хаалттай давхраажилт

Анги



Аж үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон

Эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй

Харьцангуй нээлттэй

Дээдийн
дээд
анги

Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг.

Дээдийн
доод анги

Үе залгамжилдаггүй, шинэ баячууд гэж нэрлэдэг.

Дундаас дээгүүр
анги

Өндөр боловсролтой, нарийн мэргэжсэн мэргэжилтнүүдийн анги.
Цагаан захтнууд

Дундын дунд анги

Жижиг бизнес эрхлэгч, инженер, төрийн дунд тушаалын албан
хаагч зэрэг цагаан захтнууд, нарийн мэргэжсэн хөх захтнууд

Ядуу ажилчин анги

Маш бага орлоготой, мэргэжилгүй энгийн
ажилчид

Доод анги

Ядуус. Бага боловсролтой, эсвэл боловсролгүй хөдөлмөр
эрхлэх чадвар муутай. Ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй.

Ёроол хэсэг

Орон гэргүйчүүд, хар тамхи, архинд донтогсод

Баялаг

Нэр хүнд

Давхраажилты
Н
ХЭМЖИГДЭХҮҮН

Эрх мэдэл

Боловсрол


... Нийгмийн бусад гишүүдийн зүгээс олж авсан хүндэтгэл, нэр төр, алдар хүнд хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргийг багтаадаг субъектив шинжтэй.

... Тодорхой бодгаль бусдаасаа илүү хүчтэй давамгай байхтай холбогддог. Тодорхой субъектод хууль ёсоор олгосон эрх хэмжээгээр тодорхойлогдоно.

Хувьцаа, хадгаламж, үл хөдлөх зэрэг үнээр илэрхийлэгдэх бүх эд хөрөнгө багтдаг.

Монголын нийгмийн давхраажилт

Манжийн үеийн тухай өгүүлсэн эх сурвалж ... Манжийн эрхшээлийн үед Монголын нийгэм нь олон давхраанаас бүрдэж байв. Нийгмийн давхрааны дээд хэсэг нь хошууны **ноёд, тайж, лам нар** байв... Нийт монгол хошуудын засаг ноёд нь уг гарлаараа 5 янз байв. Тэднээс хамгийн олон нь алтан ургийн ноёд юм... жирийн **малчин ард** нийгмийн дунд давхрааг голлон бүрдүүлж байв. Тэд тухайн хошуу ноёд, тайж нар, хутагтад харьяалагдан, тэдэнд татвар нийлүүлэх, мал сүргийг нь адгуулан үржүүлэх үүрэг хүлээж байв... доод давхраа нь **гэрийн боолчууд** байв. Эх сурвалж: Очир А, Энхтүвшин Б (ред). Монгол улсын түүх. IV боть. УБ хо





1990 оноос хойш Монголын нийгмийн давхраажилт хэрхэн өөрчлөгдсөн бэ?

1990 оноос хойшх үеийн давхраажилтын талаар судалсан Х.Гүндсамбуу, О.Мөнхбат, Ц.Уртнасан, МУИС-ийн эдийн засгийн хүрээлэн, Удирдлагын академиас явуулсан судалгаа, Үндэсний статистикийн хорооны өрхийн нийгэм эдийн засгийн байдлын судалгааны үр дүнд тулгуурлан өнөөгийн Монголын нийгмийн ангийн бүтцийг авч үзье.

Дээд анги. “Улс төр-эдийн засгийн олигархиуд” гэж нэрлэгддэг цөөнх энэ ангийг үндсэндээ бүрдүүлж байна Ц.Уртнасан (2008) энэ анги нийт хүн амын гурав орчим хувийг эзэлнэ хэмээгээд харьцангуй богино хугацаанд хөрөнгөжсөн, хэрэглээний өндөр хангамжтай, тансаг, хангалуун амьдралтай, гэрийн үйлчлэгч болон жолоочтой, тансаг тавилга бүхий орон сууц, зуслангийн байшинтай, үр хүүхдээ өндөр хөгжилтэй оронд сургадаг нийгмийн хэсгийнхэн багтана гэжээ.

АТГ-т гаргасан УИХ-ын гишүүдийн хөрөнгө орлогын мэдүүлэг (2016)аас харахад нийт гишүүдийн 18.4 хувь нь тэрбумаас дээш орлоготой буюу хадгаламжтай бол зөвхөн 2.6 хувь нь ямар нэг ААН-д хувьцаа эзэмшдэггүй байна

Дундын дээд



төр засгийн дунд тушаалын албан тушаалтан, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлага, банк санхүү, томоохон аж ахуйн нэгжийн захирал, эзэд, соёл, урлаг, спортын элит бүлэг багтдаг болохыг судлаач О.Мөнхбат тэмдэглэжээ.

Судлаач Ц.Уртнасангийн үзэж байгаагаар энэ ангийнхан нийт хүн амын 8-15 хувийг эзэлдэг байна.



Дундын доод анги



Жижиг дунд аж ахуй нэгжийн захирал, менежер

Их дээд сургуулийн багш, эрдэм шинжилгээний ажилтан

Цэрэг цагдаагийн байгууллага, Шүүх байгууллага, чинээлэг малчид 30-35 хувь

Нийт хүн амын гурван хүн тутмын нэг нь энэ ангид багтаж байна.

Доод анги

Доодын дээд

2010 оны хүн амын тооллогын дүнгээс харахад нийт ажил эрхэлдэг хүн амын 7.5 хувь, ойролцоогоор тооцоолбол нийт хүн амын 8.9 хувь нь энгийн ажилчид байна.

Доодын дунд

Судлаач Гилберт, Калл нарын үзэж байгаагаар энэ анги нь бага боловсролтой эсвэл боловсролгүй, хөдөлмөр эрхлэх чадвар муутай, өөртөө итгэх итгэлгүй, маш бага орлоготой эсвэл тогтмол орлогын эх үүсвэргүй хүмүүсээс бүрддэг гэж үзсэн.

Ёроол

орон гэргүйчүүд, тэнүүлчид, хар тамхи, архинд донтогч, биеэ үнэлэгчид бүрдүүлнэ

2010 оны байдлаар Нийслэлийн хэмжээнд орон гэргүй, тэнэмэл амьдралтай 1036 хүн бүртгэг

*Уламжлалт
нийгэм*

- Цэрэг арми
- Шашин сүм хийд

*Орчин
үеийн
нийгэмд*

- Боловсрол
- Хөдөлмөр
- Урлаг, спорт
- Гэрлэлт
- Улс төрийн үйл ажиллагаа

Нийгмийн нийтлэгүүдэд тэгш бус байдалд холбогдох ямар асуудлууд байдаг вэ?

- ❑ Жендэр
- ❑ Угсаатны нийтлэг
- ❑ Насны нийтлэг
- ❑ Шашны нийтлэг





	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
Сайд	16	14	87.5	2	12.5	16	14	87.5	2	12.5	16	14	87.5	2	12.5
Дэд сайд	13	8	61.5	5	38.5	13	8	61.5	5	38.5	13	8	61.5	5	38.5
Засаг дарга /аймаг, нийслэл/	22	22	100.0	-	-	22	22	100.0	-	-	22	22	100.0	-	-
Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/	35	29	82.8	6	17.2	37	32	86.5	5	13.5	37	32	86.5	5	13.5

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл

Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь яамдын төрийн нарийн бичгийн түвшинд 7.7%, агентлагийн даргын түвшинд 3.3%, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын түвшинд 18.2% байгаа бол аймаг, нийслэлийн ИТХ-ын даргын түвшинд байхгүй байна.

Хүснэгт 2. Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын тоо, хүйсээр, 2016-2018 он

Төрийн захиргааны удирдах албан тушаалтан	2016				2017				2018						
	Бүгд	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	хувь	тоо	хувь		тоо	хувь	тоо	хувь		тоо	хувь	тоо	хувь
Яамдын ТНБ	13	12	92.3	1	7.7	13	12	92.3	1	7.7	13	12	92.3	1	7.7
Агентлагийн дарга	27	27	100.0	-	-	27	27	100.0	-	-	30	29	96.7	1	3.3
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	20	90.9	2	9.1	22	18	81.8	4	18.2	22	18	81.8	4	18.2
Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга	22	22	100.0	-	-	22	22	100.0	-	-	22	22	100.0	-	-
Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	22	18	81.8	4	18.2	22	18	81.8	4	18.2	22	18	81.8	4	18.2

Эх үүсвэр: Төрийн албаны зөвлөл



ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ

ЭМЭГТЭЙ

ҮҮРЭГ

Үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх ажлыг гардан хийхдээ сайн.

ХҮЛЭЭЛТ

Нөхөр хангалттай мөнгө олдог бол эмэгтэйчүүд ажил хийх шаардлагагүй.

ХАТАН УХААН

Нягт нямбай, хөдөлмөрч халамжтай, дуулгавартай, тэвчээртэй, гуалиг, уян зөөлөн байх ёстой.

ХҮҮХЭД

Ээжүүдийн ажил эрхлэлт, карьер хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг.

АЖИЛ МЭРГЭЖИЛ

Эмэгтэйчүүдийн байгалийн зан чанар нь эмч, багш зэрэг ажилд тохиромжтой.

УР

Нарийн нямбай учир удирдах биш, гүйцэтгэх ажилд тохиромжтой.

01

02

03

04

05

06

ЭРЭГТЭЙ

ХАРИУЦЛАГА

Гэр бүлээ тэжээж, нийгэмд үйлчлэх ёстой.

ОЙЛГОЛТ

Хангалттай орлого олдог бол эхнэрээ ажил хийлгэх шаардлагагүй.

НОЁН НУРУУ

Хатуу чанга, хүчирхэг, гүндүүгүй, ноён нуруутай байх ёстой.

ГЭР БҮЛ

Гэр бүлээсээ илүү ажил мэргэжилдээ цаг гаргаж болно.

АЛБАН ТУШААЛ

Аймаг, хот, улсын захиргаа, удирдах албан тушаалд эмэгтэйчүүд илүүтэй тохирно.

ЧАДВАР

Алсын хараатай, том асуудалд илүү чадварлаг ханддаг тул удирдах ажилд давамгайл оролцох ёстой.


❑ НАСНЫ НИЙТЛЭГ




- ❖ Жишээ нь эцэг эхчүүд 8 настай хүүхэдтэй гэрлэлтийн тухай ярихгүй бол 30 нас хүрсэн хэрнээ гэрлээгүй хүүхэддээ хурдан гэрлэхийг байнга сануулна.
- ❖ Японд нас ахих тусам нийгмийн байр суурь нь өсдөг зүй тогтол ажиглагддаг. Харин манайд ийм хандлага илэрдэг ч зарим тохиолдолд 35-аас дээш насныханд шинээр ажилд орох боломж бусад насныхнаас харьцангуй бага болох нь ажлын байрны зарнаас харагдах жишээтэй.

WIN/Gallup International байгууллагын дэлхийн 66 улс орны 66000 гаруй иргэдийг хамарсан "Шашин шүтлэг, сүсэг бишрэл"-ийн судалгаанд MMCG компани Монгол улсаа төлөөлөн хамтран ажиллалаа.

ДЭЛХИЙН ШАШИН ШҮТЛЭГИЙН СУДАЛГАА




ШАШИН, ШҮТЛЭГ ОРЛОГООР



Дэлхий дээрх 10 хүн тутмын 6 нь (62%) өөрсдийгөө шашин шүтлэгтэй гэж үздэг бол 1/4-ээс бага хувь нь (25%) өөрсдийгөө шашингүй, харин 9% нь өөрсдийгөө atheist буюу шашны эсрэг үзэлтэн гэж үзэж байна.

Судалгаанд оролцогчдын орлого нэмэгдэхэд шашин шүтлэгийн түвшин буурч байна. Бага орлоготой хүмүүсийн 66% нь өөрсдийгөө шашин шүтлэгтэй гэж үзэж байхад орлого өндөртэй хүмүүсийн хувьд 50% болж буурч байна.

ШАШИН, ШҮТЛЭГ БОЛОВСРОЛООР



Боловсролын түвшингийн хувьд мөн ижил хандлагатай байна. Боловсролын түвшин доогуур хүмүүсийн 83% нь шашин шүтлэгтэй бол өндөр боловсролтой хүмүүсийн 49% нь шашин шүтлэгтэй байна.

ДЭЛХИЙН ХҮН АМЫН 62% ӨӨРСДИЙГӨӨ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ГЭЖ ТОДОРХОЙЛДОГ.

ТЭГШ БУС БАЙДАЛ

БУРАНГУЙ ҮЗЭЛ

АЛАГЧЛАЛ

Бурангуй үзэл нь нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага билээ


алагчлал нь нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй бодит үйлдэл аж.

А нь 1974 онд Налайх дүүрэгт уурхайчин А-ийн гэр бүлд төрсөн. 1980 онд 8-р анги төгссөн. 1982 онд ТМС төгсөн уурхайчин болсон. 1990-1995 онд Налайхын уурхайд уурхайчнаар ажилласан 1995 оноос хойш хувиараа нүүрс олборлож байна. Сарын орлого 600, 000 төгрөг. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.

В нь 1974 онд Швейцари улсын Женев хотноо дипломатч В-ийн гэр бүлд төрсөн. 1992 онд бүрэн дунд боловсролыг эзэмшсэн. 1996 онд Оксфордын их сургууль төгссөн. 1998 онд тус сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 1998 онд өөрийн компани байгуулсан. 2012 оноос хойш дэд сайдаар ажиллаж байна. Сарын орлого 30 сая төгрөг. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

Б 1974 онд Улаанбаатар хотод Б гэдэг эмэгтэйн гэр бүлд төрсөн. 1985 онд гэрээсээ дайжсан Мөн онд сургуулиас гарсан. Хулгайн гэмт хэрэг удаа дараа үйлдсэний учир 10 гаруй жилийг шоронд хоригдсон ба өөрийн гэсэн гэр оронгүй. Эхнэргүй, мөн хүүхэдгүй.

Г нь 1974 онд Өвөрхангай аймгийн Хужирт суманд малчин Г-ийн гэр бүлд төрсөн. 1992 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. 1996 онд их сургууль төгссөн. 1996-1998 онд банкны эдийн засагчаар ажилласан 1998-2002 салбарын захирал, 2002-2010 банкны дотоод аудитын газрын дарга, 2010 оноос хойш дэд захирлын албыг хашиж байна. Сарын орлого 10 сая төгрөг. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.



Тухайн нийгэмд байр суурийн төлөөх шударга өрсөлдөөн хэр зэрэг илэрч байгааг нийгэм дэх байр суурийн босоо чиглэлийн болон үе хоорондын шилжих хөдөлгөөн харуулах юм. Америкийн социологич Л.Козер байр суурийн шилжих хөдөлгөөний асуудлыг судалсан. Тэрээр судалгааны үр дүндээ тулгуурлан хаалттай ба нээлттэй нийгэм хэмээн нийгмийн хоёр хэв маягийг тодруулсан байна. Босоо чиглэлийн, хувийн, үе хоорондын байр суурийн шилжих хөдөлгөөн хийх боломжтой нийгмийг нээлттэй нийгэм гэжээ. Байр суурийн шилжих хөдөлгөөний дурдсан төрлүүд хэрэгжих боломжгүй нийгэм нь хаалттай нийгэм байна.

БООЛЫН
НИЙГЭМ

ФЕОДАЛЫН
НИЙГЭМ

КАПИТАЛИСТ
НИЙГЭМ

КОММУНИСТ
НИЙГЭМ

Ан агнуурын
нийгэм


Цэцэрлэг аж
ахуйн нийгэм

Газар
тариалангийн
нийгэм

Аж
үйлдвэржсэн
нийгэм

К. Маркс Азийн нийгмийг өрнөдийн нийгмийн туулж өнгөрүүлсэн хэв маягаас ялгаатай гэж үзсэн.

Бүтэц чиг үүргийн онолчид: Г. Ленский, Ж. Ленский нар нийгмийн дараах хэв маягууд байна гэж үзсэн байна.



Германы социологич Ф. Тённис аж үйлдвэржилтийн нийгмийг өмнөх үеэс нийгмээс ялгарах ялгааг тодруулсан.

- Гемайншафт хөдөөний буюу уламжлалт ёс заншил, шашин шүтлэг онцгой нөлөөтэй тул хувийн хүсэл зориг багатай, хамт олны зарчим
- Гезеллшафт буюу орчин үеийн шашин шүтлэгийн нөлөө багассан тул хувийн сонирхол их болдог.

Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх НИЙГЭМ

- ✓ Газар тариалангийн аж ахуй болон түүнээс өмнөх хэлбэрийн аж ахуйтай
- ✓ Шашны болон домгийн итгэл үнэмшилтэй
- ✓ Уламжлалт төрийн бүтэцтэй
- ✓ Хамт олны зарчим үйлчилдэг
- ✓ Хүний амьдралын гол талбар нь өрх, гэрийн хүрээ байна.

Орчин үе буюу аж үйлдвэржсэн нийгэм

- ✓ Аж үйлдвэр эдийн засгийн гол талбар
- ✓ Шинжлэх ухаан
- ✓ Орчин үеийн төрийн бүтэц
- ✓ Хувийн хүсэл зориг
- ✓ ОНБ, олон талт харилцаа

Уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэм болон өөрчлөгдөхийг шинэчлэл буюу (modernization) гэдэг.



Сэтгэгчид нийгмийн хэв маягийг ангилахдаа ямар шалгуурт тулгуурласан бэ?

К Маркс

Эдийн засгийн нөөцийг хэн эзэмшиж, ашиглаж байгаад түүнд ямар өөрчлөлт гарч байгаатай

Г.Ленский,
Ж. Ленский

Амьдарч оршин байх арга хэрэгсэл түүнийг олж авч байдал

Ф.Тённис

Газар тариалан, хөдөөгийн уламжлалт нийгэм, аж үйлдвэрийн нийгмийн ялгарах шинж

Т.Билтон

О

Аж ахуй, эдийн засаг Төр, нийгмийн бүтэц Хувийн хүсэл зорилго, итгэл үнэмшил